



Өвөрхангай аймгийн ИТХ-ын
2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн
IV хурлаар хэлэлцэн батлав.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО (2007 - 2015)

Арвайхээр хот
2007 он

ГАРЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

- А. Эрхэм зорилго, баримтлах зарчим 4-4
- Б. Хөгжлийн бодлого боловсруулах үндэслэл.шаардлага 4-5

Хоёр. Аймгийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл5-6

Гурав. Аймгийн хөгжлийн зорилтууд, тэдгээрийн үндэслэл, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1. Аймгийн эдийн засгийн үндсэн салбаруудын хөгжлийн бодлого 6-15
 - 3.2. Аймгийн дэд бүтцийн салбарын хөгжлийн бодлого 15-17
 - 3.3. Хүн ам зүйн болон нийгмийн хөгжлийн бодлого18-25
 - 3.4. Байгаль орчны бодлого, арга хэмжээ 25-31
- Дөрөв. Хөгжлийн удирдлага, зохион байгуулалт 31-33
- Тав. Ашигласан материал 33-34

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО /2007-2015/

Нэг. Нийтлэг үндэслэл

А.Эрхэм зорилго, баримтлах зарчим

Өвөрхангай аймгийн ХӨГЖЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО бол: "Хүн бүр ажил хөдөлмөр эрхэлж, аймгийнхаа нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх явдал мөн" гэж тодорхойлж байна.

Энэхүү эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд "Хөгжлийн төлөө харилцан бие биеэ дэмжин тусля" гэсэн зарчмыг баримтлана.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд Өвөрхангайчууд бидэнд:

- Монгол Улсын түүх, байгаль, соёлын хамгийн үнэт өв, бахархал;
- Бидний ирээдүйн хөгжилд суурь болох байгалийн ил, дагд асар их баялаг;
- Нүүдлийн соёл иргэншлийн өв болсон бэлчээрийн мал аж ахуй;
- Их Монгол Улсын өв болсон Хархорум , түүнийг бүтээн босгосон ард түмний үр сад бид;
- Өнөөгийн бидний бие бялдар, оюун санаа, боловсролын түвшин хөгжил дэвшилд хүрэх нөөц боломж байна. Энэ бол бидний үнэт зүйл мөн.

Б. Хөгжлийн бодлого боловсруулах үндэслэл, шаардлага

Аймгийн хэтийн хөгжлийн тогтсон чиг баримжаа тодорхой бус байгаа тул энэхүү хөгжлийн бодлогыг тодорхойлж байна.

Тус аймгийг хөгжүүлэхэд бидэнд дараах давуу талууд байна. Үүнд

- Байгаль, газар зүйн тааламжтай нөхцөл, байрлалд оршдог ;
- Хөгжлийн суурь нөхцөл болсон дэд бүтэц, ялангуяа эрчим хүч, холбоо, зам харилцааны хүрэлцээ, хангамжийн хувьд бусад аймгуудаас харьцангуй давуу, цаашид улам өргөтгөн сайжруулах замаар аймгийн хөгжилд таатай нөлөө үзүүлэх боломжтой;
- Байгалийн нөхцөл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн туршлага, чадавхидаа тулгуурлан хөгжих;

- Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх эрдэс баялгийн олон илэрц, нөөцүүд, тухайлбал, үнэт, өнгөт, ховор ба хар металл, нүүрс, занар, битум, барилгын материалын нөөцтэй;
- Аймгийг бүхэлд нь хамарсан аялал жуулчлал, амралт сувилалын цогцолборууд байгуулан хөгжүүлэх бэлэн нөөц, боломжуудтай;
- Хүний болон мэргэжилтэй боловсон хүчний харьцангуй чанартай нөөцтэй зэрэгтээ тулгуурлан аймгийг хөгжүүлэх бодлогоо тодорхойлж байна.

Гэхдээ хөгжилд саад болж байгаа зарим тодорхой бэрхшээлийг даван туулах арга замаа судалж, эдгээрийг арилгах чиглэлээр ажиллана. Үүнд:

- Аймгийн хөгжлийн нэгдсэн бодлогыг хангахын тулд бүх иргэдийнхээ хүч боломжийг нэгтгэн чиглүүлж, дэмжин туслах бодлого чиглэлээ шинэчлэн боловсруулах;
- Аймгийн хөгжлийн өнөөгийн цар бага, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл цөөн, чанар доогуур, ажлын байрны тоог нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал, иргэдийн нилээд хувь нь хагас ажилгүйдлийн байдалтай, ил, далд ажилгүйдлийн тоо, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоог бууруулах;
- Хүн амыг орон нутагт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, иргэдийг өөрсдийгөө хөгжүүлэх, шинэ мэргэжил, мэдлэг эзэмших замаар амьдралаа дээшлүүлхийг бүх талаар дэмжих ;

Хоёр. Аймгийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл:

Тус аймгийн эдийн засгийн бүтэц нь хөгжлийн шаардлагад төдийлөн нийцээгүй байна. Тухайлбал, аймгийн ДНБ-ний 70 гаруй хувийг бэлчээрийн мал аж ахуйн бүтээгдэхүүн эзэлж байгаа нь байгаль, цаг агаарын нөлөөнөөс шууд хамаардаг, эрсдэлтэй эдийн засагтай байгаа юм. Энэ байдлаас гарахын тулд аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүний тулд:

- Ашигт малтмалынхаа нөөцөд тулгуурлан уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх;
- Бэлчээрийн мал аж ахуйн одоогийн түвшинг хадгалж, улмаар зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу эрчимжсэн мал аж ахуйг төв суурин газрыг дагуулан хөгжүүлэх;
- Усалгаатай газар тариаланг түлхүү эрхлэх замаар, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, дотоодын хэрэгцээг;
- Хөдөө аж ахуйн түүхий эд, байгалийн нөөц баялагт түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Аялал жуулчлал, рашаан сувилалыг эрчимтэй хөгжүүлэх ;
- Иргэн бүрийг сурч боловсрох нөхцөлийг хангаж, чанартай боловсрол эзэмшүүлнэ ;
- Хүн бүрийг эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлнэ;

Дээрх хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Орон нутгийн түүхий эд, нөөцдөө түшиглэсэн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг олноор байгуулан хөгжүүлэх, иргэдийнхээ хунсний болон бусад хэрэглээг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангах, дотоод, гадаадын зах зээл, экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх, шударга өрсөлдөөн бий болох нөхцлийг бүрдүүлэх замаар хөгжлийн бодлогоо хэрэгжүүлнэ.
2. Сумдыг бичил бүсээр бүсчилэн хөгжүүлэх талаар өмнө хийгдсэн төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана
3. Хархорин хотыг Хангайн бүсийн тулгуур төв, Арвайхээр хотыг аймгийн хөгжлийн төв болгон хөгжүүлнэ.
4. Ашигт малтмалын орд газрыг ашиглах ирээдүйн хандлагатай уялдуулан одоогийн дэд бүтцээ өргөжүүлэх, шинээр дэд бүтэц бий болгох асуудлыг судлан шийдвэрлэнэ.
5. Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхдээ ард иргэдийнхээ идэвхтэй оролцоонд түшиглэн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын

эрх хэмжээг нэмэгдүүлэх, идэвхи санаачлагыг өрнүүлэх замаар шийдвэрлэнэ.

Гурав. Аймгийн хөгжлийн зорилтууд, тэдгээрийн үндэслэл, хэрэпкүүлэх үйл ажиллагаа

3.1. Аймгийн эдийн засгийн үндсэн салбаруудын хөгжлийн бодлого

ЗОРИЛТ 1. Хөгжлийн нөөц боломж, давуу талаа оновчтой ашиглах замаар аймгийн эдийн засгийг жил бүр 22.0 хувиар өсгөнө. Өвөрхангай аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ийг улсын дундаж хэмжээнд харьцуулснаар 2010 онд 61.4 хувь, 2015 онд 71.9 хувьд хүргэнэ.

Үндэслэл: Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ Өвөрхангай аймагт 2005 оны байдлаар 368.0 мянган төгрөг байгаа нь улсын дундажаас доогуур байна. Иймд жил бүр өсөлтийн хурдцыг 8 хувиас доошгүй байхаар төлөвлөж байгаа нөхцөлд аймгийн хөгжлийн хурдцыг илүү өндөр түвшинд төлөвлөх шаардлагатай болж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: •

- Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, аялал жуулчлал, амралт сувилалын үйлчилгээг хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж үзэн түлхүү хөгжүүлнэ. Үүний үр дүнд аж үйлдвэр, барилгын салбарын жилийн дундаж өсөлтийг 2005 оноос 0.5-1 хувиар өсгөнө.
- Аймгийн хөгжлийн бодлогыг нэгтгэн зохицуулах, судлах, дүгнэх, хяналт тавих ажлын албыг аймгийн Засаг даргын дэргэд байгуулна.
- Арвайхээр, Хархорин хотыг зах зээл төвлөрсөн бүс нутгийн томоохон хот болгох, сумдыг бичил бүсээр хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээр дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай, аж ахуйн нэгжүүдийг байгуулна.
- Шинээр бий болгох үйлдвэрлэл, үйлчилгээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй техник, технологи нэвтрүүлэхэд хяналт тавих салбарын болон аймгийн хамтарсан тогтолцоог бүрдүүлнэ.

- Аймгийн нутаг дэвсгэрт илэрсэн ашигт малтмалын орд газруудын лицензийн хяналтыг аймгийн ИТХ-ын мэдэлд төвлөрүүлж, орон нутгийн эзэмшил, оролцоотойгоор ашиглах орд газруудын жагсаалтыг гаргана.
- Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээр боловсруулсан төсөл, хөтөлбөрүүдийг Монгол улсад хандивлагчдын зөвлөлгөөн, хамтын ажиллагааны бусад томоохон арга хэмжээнүүдэд байнга танилцуулах арга хэмжээ авна.
- Ажиллах хүчний нөөц болон дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд бэлтгэх боловсон хүчний мэргэжлийн чиглэлийг хөгжлийн тэргүүлэх чиглэлээр байгуулах аж ахуйн нэгжид шаардагдах эрэлт, захиалгын дагуу бэлтгэнэ.
- Нэг суурин - нэг бүтээгдэхүүн гэсэн уриатай ажиллаж, брэнд бүтээгдэхүүний сантай болно.
- Экспортын баримжаатай жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- "Аймгийн хөгжлийн сан"-гийн бүтэц, менежментийн үйл ажиллагааг хамтын ажиллагааны чиглэлээр өөрчлөн зохион байгуулна.
- Бизнесийн инкубаторыг Арвайхээр, Хархоринд байгуулна.

ЗОРИЛТ 2. Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2010 онд аймгийн ДНБ-ний 9.3 хувь, 2015 онд 22.7 хувьд хүргэнэ.

Үндэслэл: Оновчтой, зохистой байдлаар ашиглаж чадвал аймгийн хөгжилд таатай нөлөө үзүүлэхүйц ашигт малтмалын нөөц ихтэй. Тухайлбал, тус аймагт алт, зэс, ховор ба өнгөт металл, барилгын материалын түүхий эд, нүүрс, шатах металл зэрэг 33 төрлийн ашигт малтмалын 200 орчим орд, илэрц байгаа нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд цаашид эдгээр орд, илэрцүүдэд нарийвчилсан судалгаа явуулж, нөөцийг нь тогтоох, үнэлэх, шинээр стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг нээн илрүүлэх замаар тус аймагт уул уурхайн олборлох, боловсруулах салбарыг эрчимтэй хөгжүүлэх боломж байгаа юм. Аймгийн судлагдаж тогтоогдсон орд, илэрцүүдийн ихэнхи хувийг ашиглаагүй байгаа бөгөөд зөвхөн алтны шороон

ордод олборлолт хийж байна. Нийт судлагдан тогтоогдсон орд, илэрцийн 20 орчим хувийнх нь нөөц, чанарыг үнэлсэн байна. Эдгээр үнэлэгдсэн орд, илэрцүүдийн ихэнхи хэсэг нь алтны шороон орд, нүүрс, барилгын материалын эрдэс түүхий эдийн орд, илэрцлүүд байна. Бусад эрдэс, түүхий эдийн хувьд геологийн судалгаа нь анхан шатны тойм төдийгөөр судлагдсан байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: «

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг шинээр нээн илрүүлэх, зарим томоохон илэрцүүдийн нөөцийг тогтоох чиглэлээр ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлнэ.
- Зэс, молибден, гянтболд, төмөр, хайлуур жонш, гоёлын чулуу, занар, барилгын материалын нөөцийн илэрцэд хийх хайгуулын ажлыг эхний ээлжинд дэмжинэ.
- Баянтээгийн нүүрсний уурхайн ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, нүүрсний уурхайг түшиглэн нүүрсийг дахин боловсруулах, шахмал түлшний үйлдвэрүүдийг байгуулна.
- НҮҮРС шатах материал, барилгын материалын үйлдвэрлэлээр Хангайн бүсийн хэрэгцээг хангах чиглэлээр хоршин ажиллана.
- Уул уурхайн үйлдвэрүүдэд байгаль орчинд хор хөнөөлгүй технологи нэвтрүүлнэ.
- Байгалийн нөөцийн үнэлгээний орон нутгийн санг бий болгоно.
- Аймгийн геоэкологийн судалгаа хийнэ.
- Нөөц, баялгийн бүх төрлөөр хэрэглэгч нь төлбөр төлөх тогтолцоог бий болгоно.
- Уул уурхайн ордуудыг түшиглэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- Ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон орд газрыг нийтэд ил тод зарлаж, тендэрээр шалгаруулан ашиглана.

ЗОРИЛТ 3. Жижиг, дунд үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэл хийж, хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг

олшруулах замаар 2010 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 6.0 хувь, 2015 онд 20.3 хувийг үйлдвэрлэдэг болно.

Үндэслэл: Орон нутгийн материал, түүхий эдийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл сул хөгжсөн, малын тоогоор улсад тэргүүлж байгаа боловч түүхий эдийг нь боловсруулдаггүй, цөөн хэдэн үйлдвэр нь технологийн хувьд хоцрогдсон, хүнсний чиглэлтэй байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг тодорхой чиглэлээр дагнах, терөлжих, хоршихыг бодлогоор дэмжинэ.
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төсөл, хөтөлбөр боловсруулах, гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд нь туслах албыг Засаг даргын дэргэд байгуулна.
- Жижиг, дунд үйлдвэрийн байршлыг бичил бүсийн бодлоготой хослон шийдвэрлэнэ.
- Олон улсын чанар стандартад нийцсэн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, савлах, экспортлох үйлдвэрийг Арвайхээр суманд байгуулна.
- Хиам, консервын үйлдвэрийг Арвайхээр, Хархоринд байгуулна.
- Цөцгийн тос, сүү, сүүн болон гурилан бүтээгдэхүүн боловсруулах, загас, хүнсний ногоо консервлох орчин үеийн технологи бүхий үйлдвэрийг эхний ээлжинд Уянга, Бат-Өлзий, Хужирт, Арвайхээр, Хархорин сумдад байгуулна.
- Сарлагын хөөвөр, хялгас боловсруулах үйлдвэрийг Уянга, Бат-Өлзий суманд байгуулна.
- Ноос, ноолуур, хөөвөр, хялгас, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.
- Оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрүүд байгуулахыг дэмжинэ,
- Гар урлал, бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэлийг өргөжүүлнэ.
- Савхин эдлэл, гутал, хувцас, тоноглол хэрэглэлийн үйлдвэрүүдийг байгуулна.
- Малыг түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг оновчтой байршуулахад анхаарна.

- Ингэний ундаа савлах, тэмээний ноос боловсруулах жижиг үйлдвэрийг Богд суманд байгуулна.
- Ундаа, ус, рашаан болон бусад хүнсний бүтээгдэхүүнийг савлах сав суулга, баглаа боодлын үйлдвэр байгуулна.
- "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Жил бүр Улаанбаатар хот, бүсийн хил залгаа аймгуудад үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.
- Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг эдийн засгийн хөшүүргээр урамшуулна.
- Иргэдийн хэрэгцээг хангах, ажлын байр бий болгоход чиглэсэн хөнгөн, хүнсний жижиг үйлдвэрийн зээлийн механизмыг бий болгоно.

ЗОРИЛТ 4. Барилгын материалын нөөцдөө түшиглэн бүс нутгийн барилгын материалын хэрэгцээг хангах зорилгоор энэ салбарын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд барилгын салбарын эзлэх хувийн жинг 2010 онд 2.8 хувь, 2015 онд 5.8 хувьд хүргэх зорилт дэвшүүлж байна.

Үндэслэл: Тус аймагт сүүлийн жилүүдэд зах зээлийн эрэлт хэрэгцээ өсч байгаатай холбоотойгоор тоосго, блок, хавтан, модон материал үйлдвэрлэдэг барилгын материалын жижиг, дунд үйлдвэр байгуулах шаардлага бий болж байна. 2005 онд 1106.9 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэний 61,3 хувийг нь тус аймгийн барилгын чиглэлийн аж ахуйн нэгжүүд гүйцэтгэсэн байна. Барилгын элс, чулуу, өнгөлгөөний чулуу, элс, хайрга, эрдсийн будаг, шохойн чулуу, тоосгоны шавар, шаазангийн шавар зэрэг барилгын материалын 16 орд, 16 илрэл байгаа нь тус аймагт энэ салбарыг хөгжүүлэх өргөн боломж байгааг харуулж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Арвайхээр, Хархорин сумдад тоосго, блок, суурийн хавтан, цонхны ялуу, өнгөт хавтангийн үйлдвэр байгуулна.
- Модны нөөц бүхий сумдыг түшиглэн мод боловсруулах, цонх, хаалга, цаас, деспла, фанер, аргелитийн үйлдвэр байгуулна.

- "Дөчин мянган айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд шинээр барих орон сууцны дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Барилга угсралт, худаг засварын томоохон компани байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- Барилгын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг байгуулна.

ЗОРИЛТ 5. Төв суурин газрын орчимд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь дунд хугацааны гол зорилт болж байна. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хэмжээг тогтвортой нэмэгдүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуйгаас 2010 онд 3.7 тэрбум төгрөгийн, 2015 онд 6.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Үндэслэл: Мал аж ахуй нь Өвөрхангай аймгийн эдийн засгийн гол салбар бөгөөд ДНБ-ний 3/4-ийг үйлдвэрлэж байна. Мал аж ахуйд нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйн арга технологи зонхилж байна. Аймгийн эдийн засагт мал аж ахуй голлох үүрэг гуйцэтгэж байгаа боловч мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлийн үйлдвэр хөгжөөгүй, хүн амынхаа сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Аймгийн бэлчээрийн даацыг хонин толгойд шилжүүлэн тооцож үзэхэд 2.3 сая хонин толгой бэлчээрийн даацтай байна. 2005 оны эцэст байгаа малын тоог хонин толгойд шилжүүлбэл 3.5 сая хонин толгой мал байна. Эндээс үзэхэд бэлчээрийн даац 1.2 сая хонин толгой буюу 52.1 хувиар хэтрээд байна. Үүнээс шалтгаалан бэлчээр талхлагдах, улмаар байгаль орчинд олон сөрөг үр дагавар гарч байна. Иймээс бэлчээрийн мал аж ахуйд тооноос чанарын үзүүлэлтийг чухалчлан үзэх, үүлдэр угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

Цаашид ашиг шим сайтай нутгийн шилмэл омгийн малын тоо толгойг олшруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар бэлчээрийн мал аж ахуйгаа хөгжүүлэх, хүн ам төвлөрсөн томоохон төв, суурингийн орчимд эрчимжсэн технологид түшиглэсэн фермерийн аж ахуйг олноор байгуулан хөгжүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Бэлчээрийн мал аж ахуйг зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүс нутгийнхаа байгаль орчин, бэлчээрийн даацад тохируулан үр ашигтай эрхлэн хөтлөх, төв суурин газрын дэргэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх ажлыг өргөжүүлнэ.
- Арвайхээр, Хархорин, Хужирт, Уянга сумдад хөдөө аж ахуйн цогцолбор аж ахуй, хоршоо, фермерүүдийг олноор байгуулна.
- Хархорин, Арвайхээр сумдын орчимд эрчимжсэн мал аж ахуйн бичил бүс нутгийг байгуулна.
- Махны үхрийн загвар аж ахуйг Хужирт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдад байгуулна.
- Мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй малаар нутгийн үүлдэр угсааг сайжруулах үржил селекцийн ажлыг явуулж, цөм сүргүүдийг бий болгоно.
- Өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл омгийн хээлтүүлэгч мал, өсвөр гахай, өндөглөгч бойжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдийг хангах аж ахуйг бий болгоно.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны чиглэл бүрээр сургалт зохион байгуулах үйл ажиллагааг өргөжүүлж, хөдөө аж ахуйд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, хоршооллын сургалт мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.
- Малын индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлнэ.
- Гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг мал аж ахуйг эрсдлээс хамгаалах ажилд зөв чиглүүлж, хашаа, хороо барих, инженерийн хийцтэй уст цэг засварлах, шинээр гаргах ажлыг үргэлжлүүлнэ.
- Аймаг, сум дундын отрын бүс нутагтай болох, аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Сум бүрт стандартын шаардлага хангасан мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагыг бий болгож, сум дундын оношлогооны лабораториудыг байгуулна.
- Бэлчээрийн даац, усан хангамжийг харгалзан мал сүргийг зохистой тоо, бүтэцтэйгээр өсгөн үржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, ашиг шим бүхий малын тоог олшруулахыг урамшуулна.
- Аймгийн шилмэл омгийн малын удмын сан бүрдүүлнэ.

- Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд газрыг хөнгөлөлттэй нөхцлөөр эзэмшүүлэх, бэлчээрээ зөв зохистой ашиглах, хашаалах, хамгаалах үүсгэл санаачлагыг дэмжинэ.

ЗОРИЛТ 6. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж 2010 он гэхэд хүн амынхаа хэрэгцээг бүрэн хангах, 2015 онд аймгийн ДНБ-ний 12 хувийг үйлдвэрлэдэг эрчимжсэн усалгаатай газар тариаланг хөгжүүлнэ.

Үндэслэл: Тус аймгийн газар нутгийн 9.3 хувь буюу 536.8 мян.га талбай газар тариаланд тохиромжтой хөрстэй бөгөөд энэхүү нөөцийн багахан хэсгийг ашиглаж байна. 2005 онд тус аймаг 2571.2 га-д үр тариа, 274.8 га-д төмс хүнсний ногоо тариалсан нь өмнөх оныхоосоо 25.7 хувиар буурсан байна. Цаашид газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх харьцангуй давуу нөхцөл бололцоогоо бүрэн дүүрэн, зохистой ашиглах зорилгоор энэ салбарын үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлэх шаардлагатай болж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Газар тариаланг усалгаатай эрхлэх технологийг нэвтрүүлнэ.
- Газар тариаланг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Газар тариалан эрхэлж байгаа өрх, иргэдийг үрээр хангах төслийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Тариаланд зориулж хувьчлах, эзэмшүүлэх газрын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Тариалан эрхэлдэг өрхүүдийг хоршоо (техник, багаж хэрэгсэл нь дундаа, нэгдсэн агрономитой) байгуулан ажиллахыг дэмжинэ.
- Газар тариалангийн бүтээгдэхүүнийг худалдаж авдаг, хадгалдаг, борлуулдаг корпораци байгуулах, агуулахын аж ахуй хөгжүүлэхийг дэмжинэ.
- Үр тарианы үрийн аж ахуйг хөгжүүлнэ.
- Орон нутгийн нөхцөлд тарьж болох жимс, жимсгэний аж ахуй байгуулна.
- Газар тариалангийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр үйлчлэх, сэргээн засварлах, үр бордоогоор хангах лизингийн үйлчилгээг хөгжүүлнэ.
- Зоорь, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.

- Жимс, жимсгэний тарьц, суулгац үржүүлж аймгийн хэрэгцээг хангадаг аж ахуйг зарим суманд байгуулна.
- Услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, засварлах, шинээр барьж байгуулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжиж, гадаад, дотоодын зээл, тусламжийн зохих хэсгийг түүнд чиглүүлнэ.
- Усалгаатай тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.
- Дэвшилтэт технологи бүхий услалтын систем импортлон нийлүүлэх, дотооддоо үйлдвэрлэх, барьж байгуулах, цас борооны усыг нөөцлөх үйл ажиллагааг дэмжинэ.
- Услалтын системийг олшруулах, байгалийн тогтоцыг ашиглан усны нөөцийг бүрдүүлж газар тариаланд ашиглана.
- Ганд тэсвэртэй, богино хугацааны болцтой, 1 га-гаас авах ургацын хэмжээ ихтэй үрийн сантай болно.
- Арвайхээр, Хархорин, Хужирт сумдад хүнсний ногоо даршлах цех байгуулна.
- Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн салбарыг Хархорин суманд байгуулна.
- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуйд нарийн ногоо ургуулах ажлыг дэмжиж, жил бүр "Хүлэмж" төслийн уралдаан зохион байгуулна.
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн даатгалын ба эрсдэлийн тогтолцоог боловсронгуй болгоно.
- Тэжээлийн ургамал тариалж байгаа иргэд аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

ЗОРИЛТ 7. Аялал жуулчлал, амралт сувилалыг аймгийн эдийн засгийн нэг гол салбар болгон хөгжүүлж, улмаар 2010 онд ДНБ-ний 25.0 хувийг 2015 онд 26.9 хувийг үйлдвэрлэдэг үйлчилгээний иж бүрэн салбар болгон хөгжүүлнэ.

Үндэслэл: Байгалийн, түүхийн, эрдэм шинжилгээний, уулын, усны, ан агнуурын зэрэг бүх төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, түүнтэй холбоотой үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх боломжтой. Сүүлийн жилүүдэд жуулчдын тоо

нэмэгдэж байна. Гэвч үйлчилгээний чанар, цар хүрээ муу, дэд бүтцийн хөгжил сул байна.

Монгол орны рашааны мужлалаар азотын хүйтэн, метантай хүйтэн гэсэн мужид тус аймаг багтдаг. Хужирт, Хүрэмт, Могойт, Хятруун, Эмт, Таац, Үүртийн тохой зэрэг олон рашаан бий. Цаашид рашаан сувилалыг орчин үеийн эрүүл мэндийн шинэ техник, технологитой уялдуулан нөхөн сэргээх, амралт сувилал, аялал жуулчлалтай хослон хөгжүүлэх ихээхэн боломж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аялал жуулчлалын салбарт оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, менежментийг нь сайжруулж, стандартын шаардлагыг өндөржүүлж, аймгийн сүлжээг байгуулж улмаар бүсийн болон олон улсын сүлжээтэй холбоно.
- Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах, Хархорин, Хужирт, Богд, Бат-Өлзий, Есензүйл, Гучин-Ус, ББУлаан зэрэг бичил бүсүүдийг цогцоор нь хөгжүүлнэ.
- Энэ цогцолборын хүрээнд Эрдэнэзуу хийдийг сэргээн засварлах, жуулчдыг хүлээн авах төвийг байгуулах, эртний нийслэлийн туурь дээр ил музей, Хархорин музейг байгуулна.
- Шанхын хүрээ, Төвхөн хийд, Өвгөн суварга зэрэг түүх шашин, соёлын дурсгалт газруудыг тохижуулна.
- "Мөргөлийн зам" аялалын маршрутыг бүсийн болон олон улсын аялалын маршруттай холбоно.
- Аялал жуулчлалын авто замын болон эрчим хүч, зочид буудал, үзвэр, мэдээлэл, холбооны төрөлжсөн сүлжээ бий болгоно.
- Аялалын сүлжээний дагуу шинээр жуулчны бааз байгуулах, зочид буудлын сүлжээнд холбогдохыг дэмжинэ.
- Жуулчны урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор ОХУ, БНХАУ-ын аялал жуулчлалын зах зээлийг холбосон сүлжээ бий болгоно.
- Жуулчны баазуудын материаллаг бааз, үйлчилгээг олон улсын түвшинд хүргэнэ.
- Аймгийн болон бүсийн аялал жуулчлалын холбоо байгуулахыг дэмжинэ.

- Аялал жуулчлал эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн татварын орлогыг тухайн орон нутагт оруулдаг болгох, татвар төлөх хяналтыг сайжруулна.
- Аялал жуулчлалын бүх төрлийг хөгжүүлж, жуулчдын сонирхлыг татах төрөл бүрийн арга хэмжээ (сарлаган поло, морин поло, мөсөн дээрх шагайн харваа, морь, тэмээ, сарлаг унах, автомашинаар аялах, уулын бартаат замаар дугуйгаар аялах, агаарын бөмбөрцөгөөр нисэх, шүхрээр буух, агаарын чөлөөт уналт, дельтопланаар нисэх, завь, салаар аялах, загас барих г.м)-ний нэр төрлийг олшруулна.
- Жуулчдыг жилийн дөрвөн улиралд хүлээн авах боломжтой олон улсын жишиг, стандартад нийцсэн баазуудыг байгуулж, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Аялал жуулчлалын мэдээллийн төвийг Хархорин, Арвайхээр сумдад байгуулж, энэ талын мэдээлэл сурталчилгааг хөгжүүлнэ. Дотоодын аялал жуулчлалын сулжээг өргөтгөн хөгжүүлнэ. Дотоодын жуулчдад зориулсан үйлчилгээний нэр төрлийг олшруулна. Аялал жуулчлал, амралт, рашаан сувилалын газрыг олон улсын жишгийн дагуу зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн дотоодын иргэд, байгууллагыг "Аялал жуулчлалын сан"-гаас урамшуулахыг дэмжих арга хэмжээ авна.
- Хужиртын рашааныг түшиглэн эмчилгээ, сувилалын бүс болгон хөгжүүлнэ.
- Рашаан савлах цех байгуулна.
- Хужирт, Бат-Өлзий, Нарийн тээл, Тарагт сумын халуун рашаанууд болон Улаан цутгалан, Үүртийн тохой, Могойтын рашаан, Хустын рашаан зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэсэн гадаад, дотоодын жуулчид хүлээн авах үйлчилгээний газруудыг байгуулна.
- Япон, Солонгос зэрэг Азийн орнуудын жуулчдын сонирхлыг татах байгалийн халуун рашаануудын орчныг тохижуулна.

3.2. Аймгийн дэд бүтцийн салбарын хөгжлийн бодлого

ЗОРИЛТ 1. Улсын болон орон нутгийн тээврийн сүлжээг сайжруулж, орчин үеийн түвшинд хүргэнэ.

Үндэслэл: Өвөрхангай аймагт авто тээвэр голлон хөгжсөн, усан болон төмөр зам байхгүй. Улаанбаатар-Арвайхээр, Элсэн тасархай-Хархорины чиглэлийн хатуу хучилттай замтай, Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн сайжруулсан хайрган замыг барьж байна. Мөн Хархорин-Хужиртын сайжруулсан зам, Хархорин-Хөшөө цайдамын хатуу хучилттай 46 км замыг барьж байна. Цаашид авто замын сүлжээг хөгжүүлэх, хатуу хучилттай болон сайжруулсан замыг барих явдал энэ бүс нутгийн эдийн засгийг сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Өвөрхангай аймгийг дайрсан төмөр зам тавих нь тухайн бүс нутгийн төдийгүй Баруун бүс нутгийн хөгжилд үлэмж ач холбогдол өгөх үйл явдал болох учраас ашигт малтмалын томоохон орд нээх, ашиглах нөхцлийг бүрдүүлэх, ачаа, хүн урсгалыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийнэ.
- Хархорин-Хужирт-Арвайхээр, Хархорин-Улаан цутгалангийн хатуу хучилттай авто зам барина.
- Өвөрхангай-Баянхонгорын хэвтээ чиглэлийн, Хархорин-Цэцэрлэгийн босоо чиглэлийн авто замыг хайрган хучилттай болгоно.
- Хархоринд олон улсын нисэх онгоцны буудал барина.
- Бартаат газрын зам гүүрийг засч сэлбэн, замын тэмдэгжилтийг бүрэн хийнэ.
- Угтсан болон дамжсан үйлчилгээ (зоогийн газар, зочид буудлын үйлчилгээнээс гадна машин засварын үйлчилгээ, говийн аймгуудад хэрэгцээтэй хужир шүү, давс, модон эдлэлийн худалдаа г.м.)-ний тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТ 2. Аймгийн эрчим хүчний системийг өргөтгөж, эрчим хүчний хямд, найдвартай эх үүсвэрээр хангана.

Үндэслэл: Хархорин, Арвайхээр 110 квт-ын цахилгаан дамжуулах шугамд холбогдсон. Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл сумдаас бусад

төв суурин газар төвийн эрчим хүчний системд холбогдсон. Гэвч тус бүс нутгийн хөгжлийн шаардлага, эрэлтэд нийцүүлэн цахилгаан, дулааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Баянтээгийн нүүрсний уурхайд дэвшилтэт технологи бүхий дулааны станц барих техник эдийн засгийн үндэслэл боловсруулан хэрэгжүүлж эхлэнэ.*
- Баянтээгийн нүүрсний уурхайн менежментийг сайжруулж жилдээ 50.0-аас доошгүй мян.тн нүүрс олборлон бүс нутгийн нүүрсний хэрэгцээний тодорхой хувийг найдвартай хангах нөхцлийг бүрдүүлнэ.*
- Баруунбаян-Улаан, Богд сумдыг Баянтээгийн цахилгаан дамжуулах шугамтай холбоно.*
- Хөдөөгийн малчин ерхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангана.*
- Түлш, эрчим хүчний алдагдлыг багасгаж, хэмнэлттэй технологи нэвтрүүлнэ.*
- Шингэрүүлсэн түлш, байгалийн хийг ахуйн болон үйлдвэрлэл, тээвэрт өргөн ашиглана. Ялангуяа говь, хээрийн бүсийн сумдад ахуйн хэрэглээнд хийн түлш ашиглах сүлжээг байгуулна.*
- Арвайхээр, Хархорин, Баянтээгт шахмал түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.*

ЗОРИЛТ 3. *Мэдээлэл, холбооны орчин үеийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.*

Үндэслэл: Арвайхээрээс Баянхонгор хүртэл 220 км аналог радио релейний шугам, Дашинчилэнгээс Арвайхээр хүртэл тоон релейн шугам ашиглаж, улмаар шилэн кабелиар шинэчилсэн. Багууд хөдөлгөөнт холбоотой. Арвайхээр, Хужирт, Хархорин хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдсон. Хөдөөгийн холбоонд сансрын, радио холбоо, утсан ба утасгүй

холбоо зэрэг шинэ техник, технологийг ашиглах хувилбаруудыг боловсруулан хэрэгжүүлж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Арвайрхээр, Хархорин болон бичил бүсүүдэд мэдээлэл технологийн төвүүд байгуулна.
- Дашинчилэн-Арвайрхээр чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчлэнэ. Сумдыг шилэн кабелиар холбоно.
- Ихэнх сумдад бага оврын станц болон хэрэглэгчийн нягтруулалтын төхөөрөмж ашиглан автомат холболтын үйлчилгээг бий болгоно.
- Бүх сумдыг орчин үеийн АТС болон хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбоно.
- Интернетийн үйлчилгээг сумдад нэвтрүүлнэ.
- Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг компьютержүүлнэ.
- Шууданд санхүүгийн болон электрон худалдааны үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 2010 онд суурин телефон цэгийн нягтралыг 7.50-д хүргэнэ.
- Малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах, холбоо (гар утас, утасгүй интернет), мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, зөөврийн компьютер)-ээр хангана.

3.3. Хүн ам зүйн болон нийгмийн хөгжлийн бодлого

ЗОРИЛТ 1. Хүн амд төрөлх нутагтаа мэдлэг боловсрол эзэмших, сурч боловсрох, чөлөөтэй сонголт хийх, өөрийгөө хөгжүүлэх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сонгосон мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэх, өөрийн болон гэр бүлийнхээ амьжиргааг дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангагдах, төрийн шуурхай, иргэнд ээлтэй үйлчилгээг хүртэх, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, үүрэг хүлээх, санал санаачлага гаргах, дэмжлэг урамшуулал хүртэх зэрэг тааламжтай орчин, нөхцлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Тус аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүд нь улсын дундаж түвшинд байгаа бөгөөд хөгжлийн гол хүчин зүйл болох хүний нөөц, хүний хүчин зүйлийг зөв удирдан залах, иргэдийн бүтээлч үйл ажиллагаа, идэвхи,

оролцоо, хамтран ажиллах сонирхол, санал санаачлагыг өдөөн ернүүлэх, нутгийн удирдах байгууллагаас үзүүлэх дэмжлэг туслалцааг өргөжүүлэх замаар аймгийнхаа цаашдын хөгжилд ахиц гаргах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Цаашдаа эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд хүн амын одоогийн эзэмшсэн мэргэжил, мэргэшил тохиромжгүй байгаа, зах зээлийн багтаамж багатай буюу цаашид өргөжин хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал сум, суурингийн тоо цөөнгүй байгаа нь төсөв, хөрөнгө оруулалтын нөөцийг тарамдах, хөгжилд таатай нөлөөлөх хүн ам зүйн бодлогод сөргөөр нөлөөлж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймгийн хүн ам зүйн бодлогыг тодорхойлж, хүн амын дунд байгаа өнөөгийн бэрхшээлтэй, хөгжилд саад болж буй асуудлуудыг оновчтой байдлаар шийдвэрлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Эдийн засгийн цаашдын өндөр өсөлтийг хангаж, ажлын байрыг тууштай нэмэгдүүлэх замаар гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг багасгана.
- Иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд түлхүү анхаарна;
- Арвайхээр, Хархорин хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталж хэрэгжүүлнэ;
- Бичил бүсийн төв, томоохон сумын төвийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой хэв загварыг "Булэг суурингийн тогтолцоог сумдаар зохион байгуулах төсөл"-ийн дагуу зохион байгуулна;
- "Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г дээрх бүсчлэлтэй уялдуулан боловсруулна;
- Хот суурин газрын орчин нөхцлийг сайжруулж, агаар, хөрс усны бохирдолгүй байлгах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

ЗОРИЛТ 2. Боловсролын бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлэн сургалтын чанарыг сайжруулж, материаллаг

баазыг нь бэхжүүлж, боловсролын салбарын 2015 он хүртлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Боловсролын тогтолцоо нь нийгмийн өнөөгийн шаардлага, хэрэгцээг хангаж чадахгүй байна. Боловсролын салбарт бага, дунд боловсрол зонхилж байна. Сургуулиудын сургалтын материаллаг бааз хуучирч, багш нарын мэдлэг, боловсролын түвшин өнөөгийн шаардлагаас хоцорч байна. Албан бус боловсролын тогтолцоо төлөвшөөгүй байна. Иймээс цаашид боловсролын салбарт хийх шинэчлэлийн ажлын далайцыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Томоохон төв, суурингуудад хүн амыг төвлөрүүлэх бодлоготойгоо уялдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн байршил, бүтэц, хэв шинжийг шинэчлэн тогтооно.
- Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлнэ;
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нөхцлийг сайжруулж, хичээлийн байр, анги танхимын хүрэлцээ, суудлын тоог нэмэгдүүлнэ;
- Ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудыг компьютержүүлж, интернетэд холбоно;
- Англи, орос, хятад, япон хэлний сургалтыг нэмэгдүүлж, сургалтын чанарыг сайжруулна;
- Албан бус боловсрол олгох, зайны сургалт явуулах сүлжээ бий болгох, сургалтын үйл ажиллагаанд мэдээлэл холбооны технологиийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ;
- Хүүхдэд ээлтэй сургууль, цэцэрлэгийн орчин бүрдүүлнэ;
- Мэргэжлийн сургалттай, сургалт үйлдвэрлэлийн төвүүд бүхий бүрэн дунд сургуулиудыг бий болгох ажлыг эхлүүлнэ;
- Сум бүрт сургуулийн өмнөх боловсролын ээлжийн бүлэг, зуны сургалт явуулах, гэр цэцэрлэг ажиллуулах зэрэг ажлыг зохион байгуулж, хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлнэ;
- Малчдын хүүхдүүдэд зориулсан богино хугацааны сургалтуудыг явуулна;

- Монгол улсын ШУТИС-ийн Технологийн их сургууль, Хархорины үндэсний их сургуулийг бүс нутагт шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр өргөтгөнө;
- Техникийн болон мэргэжлийн сургалтын орчныг сайжруулж, сургалтын техник хэрэгслэлийг шинэчлэнэ;
- Сургалтын ширээ, сандал болон албаны зориулалттай тавилгыг аймагтаа үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлнэ;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурч хүмүүжих нөхцөл бололцоогоор хангахад дэмжлэг үзүүлж, тусгай хэрэгцээт боловсролын анги бүлэг бий болгоно;
- Боловсролд хүйсийн тэгш байдлыг хангана;
- Хүүхдийн унаган авьяас, давуу талыг эртнээс нээн илрүүлж хөгжүүлэх арга хэмжээг өргөтгөнө;
- Мэргэжлийн сургалттай ахлах сургуулийг бий болгож бодлогын хэмжээнд дэмжиж ажиллана.
- Иргэний ёс зүйг залуу үед төлөвшүүлэх сургалт, хөтөлбөр хэрэгжүүлнэ; Албан бус боловсрол олгох, зайны сургалт явуулах мэдээлэл холбооны технологийн иж бүрэн төв байгуулна.
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэн цэцэрлэгт хамрагдалтыг 2015 онд 90 хувьд хүргэнэ.
- Аймгийн МСҮТ-ийг мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх түшиц сургууль болгон өргөтгөнө.
- Соёлын байгууллагуудын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж, соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн чиглэлтэйгээр хөгжүүлнэ.
- Аялал жуулчлалын бүсүүдэд язгуур урлагийг хөгжүүлнэ .
- Соёлын ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх мэргэжлийн сургалтуудыг тогтмолжуулж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.

- Аймгийн музейг аймаг орон нутгийн онцлог, түүх соёлын өвийг судлах сурталчилах, сургалт сурталчилгаа, аялал жуулчлал, танин мэдэхүйн төв болгон үйл ажиллагааг нь өргөтгөнө.
- Аймгийн түүх соёлын өвийн нарийвчилсан судалгааг явуулж улсын бүртгэл, мэдээллийн санд оруулна.
- Шаардлагатай нарийн мэргэжлийн чиглэлээр гадаадад сурах, мэргэжил дээшлүүлэхийг бүх талаар дэмжинэ.
- Сургууль, цэцэрлэгүүдэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээний баг бүрдүүлэн ажиллахад дэмжлэг үзүүлнэ ;
- Бүх шатны сургууль цэцэрлэгийн багш нарын мэргэшлийг дээшлүүлэх, сургалтын арга зүй технологийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх багш, удирдах ажилтаны ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлнэ ;
- ЕБС-ийн удирдлагыг мэргэшүүлэх, захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, чөлөөлөх тогтолцоог боловсронгуй болгоно.

ЗОРИЛТ 3. Эрүүл мэндийн байгууллагад үр ашигтай менежментийн тогтолцоог бий болгож, эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг бэхжүүлж, хүн амын эрүүл мэндийн талаар дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилтуудийг бүрэн хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Аймаг эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломж бүрдээгүй байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байна. Хүн амын дунд хоол тэжээлийн хомсдолын эмгэг болон халдварын бус архаг өвчин буурахгүй байна. Орчны бохирдол их, гэр бүл, хувь хүний ариун цэвэр муу байгаа нь халдварт өвчлөл тууштай буурахгүй байгаа нэг нөхцөл болж байна. Сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин, хамуу, гэдэсний халдварт өвчин гарч байна. Хүн амын эмзэг хэсгийн эрүүл мэндийг хамгаалах явдал анхаарал татсан асуудал болж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийг орчин үеийн оношлогоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр хангаж, теле анагаах ухааныг хөгжүүлнэ;

- 5000-аас дээш хүн амтай сумын эмнэлгүүдийн оношлогоо эмчилгээний чадавхийг нэмэгдүүлж, сум дундын эрүүл мэндийн үйлчилгээний бичил төв болгон хөгжүүлнэ;
- Өрх, сумын эмнэлгүүдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түлхүү хөгжүүлэх ээлтэй орчинг бүрдүүлнэ ;
- Гар аргаар алт олборлож байгаа сумын эмнэлгүүдэд түр оршин сууж буй иргэдэд үйлчлэх эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээг бий болгоно ;
- Зарим сум, багийн эмнэлгүүдийг өрхийн эмнэлгийн чиглэлээр хөгжүүлнэ ;
- Хүн амын өвчлөл, жирэмсний хүндрэлийг эрт илрүүлэх, хурдавчилсан оношлогооны сүүлийн үеийн арга технологийг сум, багийн түвшинд нэвтрүүлж үйлчилгээг шуурхай болгоно;
- БОЭТөвийн эрдэм шинжилгээ судалгааны чадавхийг дээшлүүлж, нотолгоонд суурилсан шийдвэр гарган хэрэгжүүлнэ ;
- БОЭТөвд бүсийн аймгуудын иргэдэд үйлчлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зайлшгүй шаардлагатай нөхцлийг бүрдүүлнэ ; Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг өргөжүүлэн хөгжүүлнэ ;
- Эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн засварын газрыг бий болгож, мэргэжилтнийг бэлтгэж чадавхжуулна ;
- Хүн амыг зайлшгүй шаардлагатай, чанарын баталгаатай эмээр хангах, эмийн нөөцийг бүрдүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг зах зээлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно ;
- Арвайхээр суманд эрүүл мэндийг дэмжих төв байгуулан ажиллуулах ;
- Эрүүл мэндэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Эрүүл гэр бүл" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ ;
- Орон нутгийн байгалийн баялагийг түшиглэн нөхөн сэргээх эмчилгээ, сувилалуудыг байгуулах үйл ажиллагааг дэмжиж, хөгжүүлнэ ;
- "Эмийн зохистой хэрэглээ" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх ;
- Усны хатуулаг ихтэй сумын төвд ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулж, хүн амын ундны усны чанарыг сайжруулна ;

- Биеийн тамир спортын дээд сургууль, бие бялдарыг чийрэгжүүлэх төвүүдийг байгуулан ажиллахыг дэмжинэ ;
- Орон нутгийн онцлогт тохируулан биеийн тамирын төрөл хэлбэрүүдийг өргөтгөн, байгууллага аж ахуйн нэгжүүдийн спортод ээлтэй орчин бүрдүүлэхийг дэмжин хамтарч ажиллана ;
- Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлыг сайжруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ;
- Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, амьдралын эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлнэ ;
- Эх, хүүхдэд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, ялангуяа эсэн мэнд амаржихуй, хүүхдийн өвчний цогц менежмент, хоол тэжээлийг сайжруулна ;
- Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн, үр дүнг тооцож цаашдын чиглэлийг тодорхойлно ;
- Тусламж үйлчилгээний шатлал бүрт тохирсон, үр дүнд тулгуурласан, чанарыг дэмжсэн төлбөрийн оновчтой арга, хэлбэрийг хэрэгжүүлнэ ;
- Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон материаллаг нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийн байдалд судалгаа хийж нотолгоонд суурилсан шийдвэр гарган хэрэгжүүлнэ;
- Эрүүл мэндийн байгууллагын гадаад харилцааг хөгжүүлнэ ;
- Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, технологийн дэвшлийг бүрэн ашиглах, мэдээллийн удирдлагын чадавхийг бүх түвшинд сайжруулна ;
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин өргөжүүлнэ ;
- Эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг олон улсын болон иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх тогтолцоог бий болгоно ;
- Тохиолдож болзошгүй гамшиг, шинээр буюу дахин сэргэж буй халдварын үед эмнэлгийн бэлэн байдлыг хангана ;
- Салбар хоорондын нэгдмэл зорилго тулгуурлан, үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ;

ЗОРИЛТ 4. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн эзлэх хувийг енөөгийн түвшинээс 30 иас доошгүй хувиар бууруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйдлийн түвшинг 4 хувиас хэтрүүлэхгүй байна.

Үндэслэл: Аймаг, сумын төвд үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжихгүй, ажлын байр бий болохгүй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд зөвхөн амиа аргацаасан, үйл ажиллагааны хүрээ бага байгаа нь ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлж, улмаар хүн амын тодорхой хэсгийг ядуу амьдрахад хүргэж байна. Мөн аймаг, сумын төвд малгүй өрх олон байгаа, төмс, ногоо тарьж заншаагүй, хөдөлмөрөө хоршиж хамтран ажиллах талаар санаачлага дутмаг байгаа нь ажилгүйдэл, хагас ажилгүйдлийг ихэсгэж байна. Зах зээлийг өргөтгөн хөгжүүлэх, уул уурхайн олборлох, боловсруулах

салбарыг хөгжүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг олноор байгуулах замаар ажилгүйдэл, ядуурлын асуудлыг даван туулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлнэ.
- Хүн ам, өрхийн амжиргааны түвшин, ажилгүйдэл, ядуурлын иж бүрэн судалгаа явуулж, мэдээллийн сан бүрдүүлэн энэ чиглэлээр явуулах бодлогыг тодорхойлно.
- *Ажилгүйдэл, ядууралтай тэмцэх бодлогыг хаягласан үр дүнд тулгуурласан хэлбэрээр хэрэгжүүлнэ.*
- *Иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээг өөрчлөх, хөдөлмөр эрхэлж байж л амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой гэдгийг уриалсан зөвлөгөө, мэдээлэл өгөх сургалтуудыг тогтмол явуулна,*
- *Ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн санал, санаачлагыг дэмжин ажиллаж, энэ чиглэлээр төр, иргэний нийгмийн болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангасан нийгмийн түншлэлийг бий болгоно.*
- *Эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, фермерийн аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэх, өрхийн*

үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй зээл олголтыг нэмэгдүүлнэ.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлоготой уялдуулан хөдөлмөрийн багтаамж ихтэй, нийтийг хамарсан ажилд иргэдийг өргөнөөр оролцуулна.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилчид бэлтгэх, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтад иргэдийг олноор хамруулж, сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулна.
- Шавь сургалтыг нэвтрүүлнэ.
- Ажил олгогчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, ой, гол ус зэргийг иргэдэд гэрээгээр эзэмшүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд, ажилгүйчүүд, бага боловсролтой, мэргэжилгүй иргэд, малчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг зохион байгуулна.
- Эдийн засгийн тэргүүлэх салбаруудын хөгжлийг тууштай дэмжих замаар ажлын байр шинээр бий болгох боломжийг бүрдүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, корпорац, өрхийн аж ахуй, хамтарсан өрхийн болон иргэдийн холбоо, хоршоо, нехөрлөл, хамтлагуудыг олноор байгуулах, иргэдэд зориулсан төрөл бүрийн мэргэжил олгох сургалт явуулах цогцолбор тогтолцоог бий болгох замаар ажлын байрыг олшруулж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажил олгогчдыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох бодлогыг хэрэгжүүлнэ.
- Аймгийн иргэд, байгууллагуудаас дотоод, гадаадын байгууллага, иргэдтэй хамтарч бизнес эрхлэх (ноос ноолуур, хужир шүү, загас зэрэг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ), зорилго бүхий "Бизнесийн хамтын ажиллагааны зуучлалын төв"-ийг байгуулж, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

- *Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, компаниудыг хорших, корпораций, групп байгуулан ажиллахыг бодлогоор дэмжинэ.*
- *Өнөөгийн нийгэмд ажилгүйдэл, ядуурлаас дутуугүй хор хөнөөл учруулж байгаа архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагааг эрс идэвхжүүлнэ.*
- *"Амьдрах ухаан" төсөл боловсруулан хэрэгжүүлж, иргэдийг ергөнөөр хамруулна.*

3.4. Байгаль орчны бодлого, арга хэмжээ

ЗОРИЛТ 1. *Байгаль орчинд ээлтэй бус аж ахуйн аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, байгалийн нөхөн сэргээлтэд зориулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, даацад нь зохицуулан оновчтой байдлаар мал аж ахуй болон бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах эрх зүйн таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.*

Үндэслэл: Дэлхийн байгаль, цаг уурын өөрчлөлт, хүний болон аж ахуйн зохисгүй үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль, экологийн тэнцвэрт байдлын алдагдал ихэсч байна. Мөн тус аймгийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг боловч орон нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулдаггүй (татвар төлдөггүй), байгаль, экологид хор хохирол учруулж байгаа боловч шаардлагатай нөхөн сэргээлт хийдэггүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд цөөн бус байна.

Хэрэгжүүлэх үйл ажиглагаа:

- *Аймгийн байгаль орчныг хамгаалах, зохистой байдлаар ашиглах бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.*
- *Байгаль орчныг хамгаалах орон нутгийн тогтолцоог бий болгоно.*
- *Байгалийн нөөц баялгийг нутгийн иргэдэд эзэмшүүлж, тэднээр хамгаалуулах оновчтой тогтолцоог бий болгоно.*
- *Төрөлх нутаг усаа хамгаалах талаар гарч буй иргэдийн санал, санаачлагыг дэмжинэ.*
- *Өрх бүр мод тарих хөдөлгөөнийг өрнүүлж, суулгацаар хангах, урамшуулах ажлыг зохион байгуулна.*

ЗОРИЛТ 2. Цөлжилт үүсч байгаа шалтгааныг судлан тогтоож, ургамлын бүрхэвчийг хамгаалах, ургамалжуулах арга хэмжээ авч, говь, хээрийн бүсийн эмзэг орчны унаган төрхийг хадгалах бодлого хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Аймгийн нутаг дэвсгэрийн 48.8 хувь нь говийн бүсэд хамрагдаж байгаа нь цөлжилтөд нэрвэгдэж болзошгүй эмзэг орчин их байгааг харуулж байна. Сүүлийн жилүүдэд төв суурин газарт хөрсний эвдрэл, бэлчээрийн талхлагдлаас шалтгаалан цөлжих шинж их хэмжээгээр илрэх боллоо. Иймээс говь, тал хээрийн бүсийн ургамлыг хамгаалах, заг бутыг түлшинд хэрэглэхийг багасгах, бэлчээрийн талхлагдалыг зогсоох талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Цөлжилтийн хүрээг зааглан тогтоож, эрчийг нь бууруулах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Цөлжилтийн судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгч, мэдээллийн сан байгуулна.
- Говийн бүсэд бэлчээрийн талхлагдалыг нэмэгдүүлэхгүй байх, нөхөн сэргээх ажлыг малчдын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- Говь, хээрийн бүсийн сумдын бэлчээрийн даацад малын бүтэц, тоог зохицуулах бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- Цөлжилт, элсний нүүлтэд өртөж буй газар нутгаас эхлэн заг, бут, нутгийн ургамал тариалах ажлыг нэмэгдүүлнэ.
- Говь, хээрийн бүсийн иргэдийн түлшний хэрэцээнд хий, шахмал түлш нэвтрүүлнэ.
- Цөлжилттэй тэмцэхэд идэвхи гаргасан, тодорхой үр дүнтэй ажил зохиосон байгууллага, иргэд, малчдыг урамшуулах тогтолцоог бий болгоно.

ЗОРИЛТ 3. Өвөрхангай аймгийн газар зүйн өвөрмөц онцлог, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, эдийн засаг, нийгмийг

хөгжүүлэх шаардлагад нийцүүлэн тусгай хамгаалалттай газар нутгийн цогцолборыг бүрдүүлэн хөгжүүлж, 2015 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг тусгай хамгаалалтад авна.

Үндэслэл: Өвөрхангай аймгийн хэмжээнд төрийн онцгой зориулалтад ашигладаг улсын тусгай хэрэгцээний газар 297305 га, улсын тусгай хамгаалалттай газар 290628 га, үүнээс байгалийн цогцолборт газар 269798 га, байгалийн нөөц газар 9330 га, дурсгалт газар 11500 га, батлан хамгаалах зориулалтаар олгосон газар 6600 га, эрдэм шинжилгээний сорилт, туршилт явуулах байнгын ажиллагаатай талбай 77 га тус тус байна.

Байгаль орчин, түүх, соёлын дурсгалт зүйлсээ хамгаалах, аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэх шаардлагын үүднээс тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Эдийн засаг нийгмийн хувьд үр ашигтай, байгаль экологийн тэнцлийг хангахад ач холбодолтой биологийн төрөл зүйл бүхий газар нутгийг улс, аймаг, сумын тусгай хамгаалалт, нөөцөд хамруулна.
- Хангайн нурууны унаган төрх, байгалийн үзэсгэлэнт тогтоцуудыг түшиглүүлэн байгалийн хүрээлэн байгуулах бэлтгэлийг хангана.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц баялгийг үнэлж тодорхойлох, зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэрээх суурь хийгээд хавсрага судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.
- Аймгийн нутаг дэвсгэрт оршдог байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар нутгийг тусгай хамгаалалтад бүрэн авна.
- Экологийн давтагдашгүй онцлог, ач холбогдолоороо ялгарах онцлог нутгуудыг олон улсын шим мандлын нөөц газар болгон дэлхийн шим мандлын хамгаалалттай бус болгоно.

ЗОРИЛТ 4. Ойн нөөцийг хамгаалах цоцолбор арга хэмжээ авч, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх замаар ойн санг нэмэгдүүлнэ.

Үндэслэл: Аймгийн хэмжээнд 192278 га газар ойн сан бүхий газарт хамаардаг. Үүнээс ой модоор бүрхэгдсэн (мөн загаар) газар 147192 га байна. Хангайн нурууны зүүн хэсэг, Орхон голын дагуух Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин зэрэг сумд ойн нөөцөөр харьцангуй их, аймгийн нийт ойн сангийн газрын 52.7 хувь нь ногддог. Мөн говь, цөлийн бүсэд орших Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус зэрэг сумд заг, сөөг, таримал ойгоороо ойн сангийн 32.8 хувийг бүрдүүлж байна. "Ногоон хэрэм" төслийн хүрээнд тус аймгийн 5 сумын нутгийг 300 гаруй км урттайгаар дайран өнгөрөх ойн зурвас нь цаашид аймгийн ойн сан бүхий газрыг 30 гаруй мян.га-гаар нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Тус аймгийн ой нь Монгол орны шилмүүст ойн урд хязгаар төдийгүй заган ойн хойд зах тул элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн бэрхшээлээс шалтгаалан ойжуулалтын ажил ашиглалтаасаа хоцорч байна. Ойг хамгаалах, ашиглахдаа тодорхой бодлого, хөтөлбөртэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймгийн ойн сангийн бүртгэл тооллого явуулж, мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулна.
- Ойн түймрээс урьдчилан сэргийлэх харуул хяналтыг тогтмол явуулах, сургалтын төвүүд байгуулж мэргэжлийн хүмүүс бэлтгэх, багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авна.
- Ойн түймрээс хамгаалах зурвасыг технологийн дагуу ойн нөөц ихтэй газруудад хийнэ.
- Мод сөөгний үр, боргоцой бэлтгэх. тарьц суулгац ургуулах ажлын хэмжээг жил бүр шат дараатай нэмэгдүүлж, ойжуулалтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлнэ.
- Загаар ойжуулалт хийх, ур бэлтгэх, ойжуулсан талбайг хамгаалах ажлыг ойн мэргэжлийн байгууллага болон нутгийн иргэдийн хүчээр

хийх, нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, элсний нүүлт цөлжилтөөс хамгаалах арга хэмжээ авна.

- Говийн бүс нутагт заг, харгана болон бусад бутлаг ургамал, ургаа нойтон модыг түлшинд хэрэглэхийг бүрмөсөн зогсоох, ой бүхий газруудад зөвхөн ойн арчилгаа цэвэрлэгээний журмаар мод бэлтгэж ашиглах, орон нутгийн нүүрсний ордын дэргэд шахмал түлшний үйлдвэр байгуулна.
- Хүн амын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах , хүнсний хэрэгцээг хангах зорилгоор чацаргана, үхрийн нүд, монос зэрэг жимст модыг тарьж ургуулах ажлыг өргөжүүлнэ.
- Ногоон хэрэм хөтөлбөрийг гадаад дотоодын хандивлагч байгууллагуудтай хамтран бүсийн зорилт, арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх.Өөрсдийн оршин байгаа газар, нутаг орноо ойжуулах, цэцэрлэгжүүлэх, хамгаалхад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Хот суурин газрыг ойжуулах, цэцэрлэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.
- Нутгийн иргэд, ашиглагч байгууллага, нөхөрлөлүүдэд ойн сан бүхийн газар нутгийг эзэмшүүлж хамгаалуулах ажлыг зохион байгуулах, ойн санг гэрээгээр эзэмшүүлэх, хамтын эзэмшлийн ойн хэлбэрүүдийг байгуулна.
- Тоорой, сухай зэрэг говийн ховордсон ургамлыг тарьж ургуулах, гол, горхины сав газар, булаг шандын эх, тариалангийн талбай, автозамын дагуу ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 5. Усны нөөцийг хамгаалах, арвижуулах, хүн ам, малыг эрүүл ахуйн шаардлага хангасан, хүрэлцээтэй усаар хангаж, бохир усыг цэвэршүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

Үндэслэл: Өвөрхангай аймагт 200 гаруй гол горхи, 35 нуур, 550 гаруй орчим булаг шанд байгаа нь тогтоогдсон байна. Аймгийн нийт газар

нутгийн 0.05 хувь буюу 3318.3 га газар усан сан бүхий газарт хамаардаг. Үүнээс 1524.3 га нь гол мөрний газарт, 1218 га нь нуур, тойрмын газарт, 576 га нь горхи, булаг шанд байна. Өвөрхангай аймгийн томоохон голууд болох Орхон, Онги, Таац зэрэг голууд нь Хангайн нуруунаас эх аван урсдаг бөгөөд сүүлийн жилүүдэд дээрх голуудын сав газрын урсацын хэмжээ багасаж, ууршилт нэмэгдэж, усны алдагдал ихсэж байна. Уул уурхайн зориулалтаар усан сангууд олноор байгуулах, газар тариалангийн усалгаанд ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлын бүрхэвч доройтож, херсенд нэвчих усны хэмжээ багасаж буй шалтгаанаар олон гол горхины төлөв байдал ихээхэн өөрчлөгдөж, ширгэж байна. Уул уурхайн зориулалтаар ашиглаж байгаа газар

нутагт нехөн сэргээлт хийж байгалийг унаган төрхөнд нь эргэн оруулах ажил орхигдож байна.

Цаашдаа сумдын ундны усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалах зорилгоор усны эрүүл ахуйн бүсийг тогтоох, усны эх, ундаргад онцгой бүс тогтоож, тухайн бүсэд барилга байгууламж барих, газар хагалах, ашигт малтмал хайх, олборлох, элс хайрга бэлтгэх, зэгс, шагшуурга, мод огтлох, эмийн болон хүнс, техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүх, мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглох хэрэгтэй байна.

Малын бэлчээрийн усан хангамж, хүн амын ундны усны хэмжээ, чанар нь шаардлагын хэмжээнд хүрээгүй байна. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймгийн нутаг дэвсгэр дээр газрын гадаргуугийн ус, уст цэгийн үзлэг тооллогыг явуулж, хүн амын болон эдийн засаг, хөдөө аж ахуйн хэрэглээний усны хэмжээг шинэчлэн тогтоож, мөрдөнө.
- Төв суурингийн усан хангамжыг зүй зохистой хэрэглэх талаар эдийн засгийн хөшүүргийг бий болгоно.
- Бэлчээрийн 60 аас доошгүй хувийн усан хангамжийг сайжруулна.
- Аймгийн усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг байгалийн бусад нөөцийн менежментийн төлөвлөгөөтэй уялдаатай боловсруулж хэрэгжүүлнэ.

- *Арвайхээр, Хархорин, Хужирт зэрэг томоохон төв суурин газруудын ус цэвэрлэх байгууламжыг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.*
- *Эмт, Могойт, Үүртийн тохой, Хятруун, Хүрэн хад, Хустын зэрэг рашаануудад нөөц, химийн найрлага, чанарыг тогтоох ажлуудыг хийх, аймгийн тусгай хамгаалалтад авч хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэх, ашиглалтыг сайжруулах дэс дараатай арга хэмжээ авна.*

ЗОРИЛТ 6. Биологийн төрөл зүйлийн нөөцийг тогтоох, хамгаалах талаар цогцолбор судалгаа хийж, биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Тус аймаг нь хөрсний бүтцээс хамааран уулархаг нутгаар үет ба буурцагт, хээрийн бүсэд үет болон бусад олон төрлийн ургамал, говьд бутлаг ба сонгинолог ургамал зонхилно. 72 зүйлийн хөхтөн амьтан, 110 зүйлийн шувуу, 21 зүйлийн загас, 5 зүйлийн мөлхөгч, 2 зүйлийн хоёр нутагтан амьтан нутагладаг. Ургамал, амьтны аймгийн ихээхэн баялагтай тус аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах нь зөвхөн тухайн аймгийн төдийгүй Монголын төв хэсгийн экосистемийн хувьд чухал ач холбогдолтой. Ан амьтан, ургамлын ашиглалтыг түүнийг нөхөн сэргээх, үржих нөхцлийг үл харгалзан урсгалаар явуулж байгаа тул нөхөн сэргээх боломжгүй болох аюулд хүрч болзошгүй тул уг асуудлыг нарийвчлан судалж, тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Биологийн төрөл зүйлийг хамгаалах, үржүүлэх, зохистой ашиглах аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн талхагдалд их өртсөн газар нутгийг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, бэлчээрийн талхагдалыг хязгаарлан, байгалийн аясаар нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлнэ.
- Үлийн цагаан огтоно, царцааны эсрэг байгаль орчинд хоргүй аргаар тэмцэх ажлыг хийнэ.
- Богд, Баруунбаян-Улаан зэрэг сумдын нутагт аргал, янгир зэрэг агнуурын онцгой ач холбогдол бүхий амьтдын байршил, нөөцийг тогтооно.

- Ховордсон буюу нэн ховор ан амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, удмын санг хадгална.
- Биологийн төрөл зүйлийн байршил, нөөцийг судлаж ашиглах газар нутаг, тоо хэмжээг нарийвчлан тогтоосны үндсэн дээр уг газрыг ашиглагчаар нь хамгаалуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 7. Агаар мандлыг хамгаалах, хог хаягдал, химийн болон цацраг идэвхт бодисын менежментийг сайжруулна.

Үндэслэл: Агаарын бохирдлын талаар тус аймагт тодорхой судалгаа хийгдээгүй боловч Арвайхээр, Хархорин, Хужирт, Уянга, Бат-Өлзий, Есөнзүйл сумдын төвд хүйтний улиралд агаарын бохирдол ажиглагдаж, хүхрийн хүчлийн давхар исэл, азотын давхар исэл, тоосжилтын хэмжээ улирлын чанартай хэлбэлзэж байна. .

Төв суурингийн эдэлбэр газрын 6.6 хувь буюу нэг мянга шахам га талбайд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал эзэлж байна.

Химийн болон цацраг идэвхт бодисын тархалтын талаар одоогоор мэдээ судалгаагүй байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Агаарын бохирдлын хяналт шинжилгээний лабораторийг Арвайхээр, Хархорин хотод байгуулна.
- Цахилгаан, дулаан хангамжийн системийг байгаль орчинд халгүй тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар шинэчлэнэ.
- Шинээр байгуулах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлын төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийнэ.
- Хог хаягдлыг ялган дахин боловсруулах цехийг зарим газарт байгуулна.
- Химийн хорт бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, устгалын бүртгэл судалгаа, хяналтыг сайжруулна.

Дөрөв. Хөгжлийн удирдлага, зохион байгуулалт

ЗОРИЛТ 1. Аймгийн хөгжлийг эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлыг цогцоор шийдвэрлэх хөгжлийн бодлогод нийцүүлэн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

Үндэслэл: Аймгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хөгжлийн зарчим, шаардлагыг удирдлага болгон ажиллах чадвартай, хэрэгжүүлэх ажлыг бодит үр дүнд хүргэхэд чиглэсэн шийдвэр гаргах, удирдан зохицуулах чадавхи бүхий чадварлаг тогтолцоо шаардлагатай болж байна. Ялангуяа ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, аймаг, сумын Засаг дарга, .нар, тэдгээрийн Тамгын газрын ажилтнууд, багийн Засаг дарга нарын нэгдсэн уйл ажиллагаанаас их зүйл хамаарна. Мөн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд терийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо маш чухал. Ард иргэддээ хөгжлийн бодлого зорилтоо ойлгуулж, бүх нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзэл, хүч нөөцийг дайчлах ёстой болно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймгийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө санхүү, хөрөнгө оруулалтын нөөцийг эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой, хөгжилд хүргэх арга хэмжээнд ээлж дараатай, оновчтой байдлаар хуваарилан хэрэгжүүлнэ.
- Дотоод, гадаадын зээл тусламжийн хөрөнгийг аймгийн хөгжлийн бодлого зорилтуудтай нийцсэн, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбаруудад түлхүү хэрэгжүүлнэ.
- Олон улсын болон үндэсний хэмжээнд гарч байгаа хөгжил дэвшлийн эерэг талууд, шинэ шинэ боломжуудыг аймгийнхаа цаашдын хөгжилд оновчтой байдлаар ашиглаж, төр, засгийн төв болон нутгийн захиргааны байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай үр ашигтай, олон талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөртэй уялдсан аймгийн хэмжээний бодлогыг тодорхойлон, хэрэгжилтийг нь эрчимжүүлнэ.
- Аймаг, орон нутгаа хөгжүүлэх чиглэлээр иргэд, иргэний нийгэм, аж ахуйн нэгж байгууллагаас гаргаж байгаа санал санаачлагыг дэмжин

урамшуулах, хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ-үнэлгээ хийх үйл ажиллагаанд иргэдийг өргөнөөр оролцуулах, бодлого чиглэлээ сурталчлан таниулах, хамтран ажиллах, хөгжлийн бодлогуудын хоорондын уялдааг хангах, тууштай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь үнэлэлт дүгнэлт хийж байх, шаардлагатай нэмэлт өөрчлөлт засварыг оруулж байх, бодлогын залгамж чанарыг тогтвортой хадгалах бодлогыг хэрэгжүүлнэ.

- Аймгийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа аливаа бодлого, хөтөлбөр, төслүүдийг нийт иргэдэд танилцуулах, сурталчлах, тэдний оролцоог хангах, дэмжлэгийг нь хүлээхэд чиглэсэн арга хэмжээг заавал авч хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн үйлсэд хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтолцоог бий болгоно.
- Бүх иргэдийг шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан аймаг, орон нутгаа хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа аливаа үйл ажиллагаанд бүрэн оролцуулах, энэ талаар гаргаж буй санал санаачлагыг нь дэмжин урамшуулж хамтран ажиллах тогтолцоог бий болгоно.
- Аймгийн хөгжилд нутгийн уугуул иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бусад аймаг, хотод ажиллаж, амьдарч байгаа иргэд, нутгийн зөвлөлүүдтэй оновчтой байдлаар нягт хамтран ажилладаг нэгжийг бий болгоно.
- Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ.
- Үндэсний, салбарын болон бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн талаар төрөөс баримталж байгаа хөгжлийн бодлогыг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, аймгийн хэмжээнд батлагдан хэрэгжиж байгаа хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, аймгийн хөгжлийн асуудлыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, уялдааг хангах үүрэг бүхий "Хөгжлийн бодлого, стратегийн хэрэгжилтийг хангах зөвлөхийн алба"-ыг аймгийн Засаг даргын дэргэд байгуулан ажиллуулна.

- Сумдын ЗДТГ-ын дэргэд хөгжлийн бодлого, зохицуулалтыг хариуцсан менежер ажиллуулна.
- Аймгийн хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулна.
- Эрх зүйн мэдээллийн төвүүдийг аймаг сумдад байгуулан, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Доров. Ашигласан материал

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ, 1996.
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001.06.14-ний өдрийн 57-р тогтоолоор батлагдсан.
- Монгол Улсын бүсүүдийн хөпклийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл). УИХ-ын 2003.06.12-ны өдрийн 24-р тогтоолоор батлагдсан.
- Монгол Улсын Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр. МУЗГ-ын 2005.09.28-ны өдрийн 202-р тогтоолоор батлагдсан.
- Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр (зөвлөмжийн баримт бичиг). УБ, 2005.
- Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогын төслийн холбогдолтой зарим эх материалууд
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. 2004-2008 он.
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд. УИХ-ын 2005.04.21-ний өдрийн 25 дугаар тогтоол.
- Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын тухай үндэсний илтгэл. МУЗГ. УБ, 2004.
- • Монгол Улсын эдийн засаг, нийгмийн 2006-2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл. УИХ-ын 2005.11.17-ны өдрийн 67-р тогтоол.
- Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө. УБ, 2006.
- Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө (2006-2015 он хүртэл). УБ, 2005.

- Нэг суурин-нэг бүтээгдэхүүн хөтөлбөр. МУЗГ-ын 2005.06.22-ны өдрийн 138-р тогтоолоор батлагдсан
- Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр. УБ, 1999.
- Өвөрхангай аймгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2021 он хүртэлх)
- Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал. УБ, 2006.
- Монгол Улсын тээврийн салбарын стратегийн төсөл. УБ, 2005.
- Монгол улсын нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, УБ, 2003.
- Монгол Улсад үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө. УБ, 1999.
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр. УБ, 2005.
- Хот байгуулалт, орон сууцны салбарын стратеги. УБ, 2005.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бусад салбаруудыг хөгжүүлэх үзэл баримтлал, стратеги, мастер төлөвлөгөө, хөтөлбөр, төслүүд:
- Монгол Улсын статистикийн эмхтгэлүүд. ҮСГ. УБ, 2000-2005.
- Хангайн бүсийн хөгжлийн зорилтууд (бүсийн зөвлөлгөөний илтгэл, материалуудын эмхтгэл). Арвайхээр, 2005.
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний стратегийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан. Ц.Сүхбаатар. УБ, 2006.
- Хархорин хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө. УБ, 2004.
- Өвөрхангай аймгийг төлөөлөл болгон аж ахуй, нийгмийн үйлчилгээг сумдад бүсчилэн хөгжүүлэх нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төслийн тайлан. УБ, 2005.
- Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө. УБ, 2005
- Өвөрхангай аймгийн статистикийн эмхтгэлүүд. Арвайхээр, 2000-2005.
- Өвөрхангай аймгийн хүнсний аюулгүй байдал - хоол тэжээл, хоршооллыг хөгжүүлэх, ногоон хувьсгал, жижиг, дунд үйлдвэрлэл

хөгжүүлэх зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүд, аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө зэрэг болно.